

“ЖАНГАР” ТУУЛИЙН ХЭЛ НАЙРУУЛГЫН ЗАРИМ ОНЦЛОГ

Ван Мандуга

Хураангуй: Тус өгүүлэлд “Жангар” судлалын олон чиг хандлагаас урлаг, уран сайхны талыг нь гүн гүнзгий задлан шинжилж судлахын чухлыг онцлон заагаад “Жангар” туулийн хэл найруулгын мөн чанарыг:

Нэг: Хэтрүүллийн ахуйгаас давсан цаг, орон зай

Хоёр: Уран нарийн зүйрлэлийн монголжуу онцлог гэх хоёр талаас шинжилжээ.

Түлхүүр үг: *Жангар, тууль, хэл найруулга, хэтрүүлэл, цаг, орон зай, зүйрлэл*

“Жангар” тууль ямар онцлог, учир шалтгаантай учраас олон зуун жилийн турш монголчуудын оюуны тэжээл болж, өргөн хэмжээгээр уламжлагдан тархаж, өнөд гандан буурашгүй соргог цэцэг шиг гэрэл гялбаа цацруулж мөнх амилж чадсан бэ? гэвэл юуны өмнө тэр бол монгол ардын оюун ухаан билиг авьяасын талст урлагийн бүтээл болоход оршино. Ардын аман зохиол доторх биеэ даасан томоохон төрөл баатарлаг тууль болох “Жангар” нь өөрийн урлаг уран сайхны ид шидээрээ даяар олны сэтгэлийг сорж, гоо сайхны ухамсрыг хөгжөөн, саруул оюуныг нь ундалж урлагийн хүртээл болсоор иржээ. Нэн тодруулан хэлэхэд “Жангар” тууль оршин байх урт удаан түүхэн явцдаа улам улмаар төгөлдөржин боловсорч монголчуудын дунд өргөнөөр тархан дэлгэрч уламжлагдсан явдал нь дан ганц түүнд тусгагдсан монголын нийгэм түүх, улс төр, эдийн засаг, гүн ухаан, шашин суртахуун, зан үйл, ёс суртахуун, хууль цааз зэрэг олон талын агуулгад нь л байх биш, харин хамгийн чухал нь хэлний урлаг болсон уран зохиолын онцгой шинж-урлаг уран сайхан гоо таашаалын үнэ цэнд нь байгаа юм. Ийм учраас “Жангар” судлалын олон талын чиг хандлагаас урлаг, уран сайхны онцлог талыг нь чухалчлан авч үзэх хэрэгтэй гэж би хувьдаа үзэж байна. Ингэж үзвэл, сая “гадаадыг дунддад таниулах” эртнийхийг эдүгээчлэхэд үйлчлүүлэх зорилгоор эртний монголчуудын уран зохиолын өв сан дотроос содон сайхан, гэрэл гялбаа бүхий уураг шимийг шингээн авч, дүр бүтээлт, зохиомж бүтэц, урлах эрдэм, хэл найруулга зэрэг талын эрхэм үнэт туршлагыг дүгнэн залгамжилж, өнөөдрийн монгол уран зохиолын туурвилын бодит үйлдлэгтэй толь болгон ашиглаж, “Жангар” судлалын бодит ахуйч ач холбогдлыг нэмэгдүүлж чадна. “Жангар” туулийг чухам тулгар бичгээр үзэж, түүнд тусгагдсан эл зүйлийн нийгмийн агуулга (түүх, гүн ухаан, улс төр, эдийн засаг, шашин шүтлэг, хууль цааз ... гэх мэт) хийгээд хэл хэллэгээр баримт болгож, монголын нийгэм түүх, гүн ухаан, улс төр, эдийн засаг, шашин шүтлэг, хууль цааз зэргийг судлахыг гол болгох юм уу? Эсвэл түүнийг урлагийн бүтээл аман зохиолоор үзэж, түүний урлаг, уран сайхны нууц, онцлог шинж, гоо таашаалын үнэ цэнийг үнэлж цэгнэхийг гол болгох юм уу? гэдэг нь анхааруштай асуудал юм.

“Хэл бол утга зохиолын тэргүүн элемент мөн” гэж оросын нэрт зохиолч М.Горький нэгэнтээ өгүүлсэн билээ. Хэлний урлаг болсон утга зохиолд хэлний үзүүлэх нөлөө, ач холбогдлыг ингэж чухалчлан үзэх нь зүй ёсны хэрэг. Ойрад монголчуудын олон үеийн урлагчид-Жангарч нарын хайлан боловсруулж хэвшүүлсэн “Жангар” туулийн хэл найруулга нь энэхүү гайхамшигт

туулийн үнэ цэнийг илэрхийлэх аж. Иймд “Жангар” туулийн амаас ам дамжин уламжлагдаж ирсэн уран яруу, цэвэр тунгалаг хэл найруулга, улмаар дүр дүрслэлийн урлалыг тогтолцоотой судлах явдал бол маш чухал ажил болно. Энэхүү өгүүлэлд зөвхөн “Жангар” туулийн хэл найруулгын зарим онцлогийг онцлон авч үзэхдээ хэл найруулгаар дамжуулан зохиолын агуулга, утга санаа хэрхэн гүнзгийрч байгааг өгүүлэв.

Нэг: Хэтрүүллийн ахуйгаас давсан цаг, орон зай

“Жангар” туульд уран дүрслэлийн аргын нэг болох хэтрүүллийг өргөн хэмжээнд зохист хэл найруулгаар уран нарийн хэрэглэж, юм үзэгдлийн мөн чанар, учир шалтгааныг тайлбарлахдаа бодол санаагаа тун уран яруу, дөхөм ойлгомжтой, уран сайхан хэлбэрээр дүрслэн илтгэсэн байдаг. Жишээлбэл хол, ойрд алдар нэрээ мандуулсан Богд Жангарыг магтахдаа:

Доордын долоон орны дууч болсон

Дээдийн долоон орны зүүдэн болсон

Ойрын тивүүдийг төрөхдөө мөргүүлсэн

Холын тивүүдийг нэрдээ сүрдүүлсэн (МТБЦ, 1989:1165) гэж дүрсэлжээ. Товч тодорхой хийгээд уран яруу дөрөвхөн мөр шүлгээр Жангарын алдар нэр тархсан орон зайн хэмжээг зураглаж, эртний монголчуудын гүн ухаан, гурван ертөнцийн тухай үзлийн зарим онцлогийг гүнзгий тусгасан байна. Эртний монголчууд орчлон хорвоог дээд тэнгэр, доорд там, дунд хүний орчлон хэмээх гурван орноос бүтсэн гэж үздэг байжээ. Дээрх дөрвөн мөр шүлэгт Жангарын алдар нэр өөрийнх нь оршиж байгаа хүний орчлонгийн орон зайн хэмжээнээс хальж, гурван ертөнцөд тархсан гэдгийг урнаар илтгэж, энэхүү гурван ертөнцийн тухай өнгөрсөн, одоо, ирээдүй гурван цагийн дээд, дунд, доорд гурван ертөнц хэмээх энэхүү ахуйгаас давсан өргөн уудам цаг, орон зайд амьдран оршиж байгаа бүх хүн ард Жангарын алдар нэрийг сонсоод шүтэн биширч, ойр нь түүний “төрх”-д мөргөж, хол нь түүний “нэр”-д сүрдэж байгаа аж. Энд “мөргөх” хэмээх үгийг уран хэрэглэж, шүтэн бишрэх ард иргэдийн үйл хөдлөлийг жаргуулахын хамт тэдний гэнэн хонгор шударга сэтгэл хийгээд шашин шүтлэгийн заншлыг ч тодорхойлон илтгэжээ.

“Жангар” туульд ахуйгаас давсан орь хүслэнгийн орон-Ар бумбын орныг ингэж дүрсэлж байна:

Үхэлгүй мөнхийн оронтой

Үргэлжид хорин таван насны дүрээр байдаг

Өвөлгүй хаврын хэвээр

Зунгүй намраар

Даарах хүйтэнгүйгээр

Халах халуунгүйгээр

Сэр сэр хийсэн салхитай

Бур бур хийсэн бороотой (1989:20) гэж дүрсэлжээ. Ингэж дайн дажингүй, үхэл зовлонгүй, мөлжлөг дарлалгүй, аюул гамшиггүй энх тайван эрх чөлөөт Утопи маягийн хүслэнгийн орныг бодит ахуйгаас давуулан зураглаж дүрсэлжээ. Энэ нь хятадын зохиолч До Юань Мины зурагласан хүслэнгийн орон-“Тоорын цэцгийн ойллого” дахь До Хуа Юань-аас ч нэн давуулж, нэн хүслэнжүүлсэн зураглал болжээ. Хүний үхэж төрөх, өвөл, хавар, зун, намар гэсэн жилийн дөрвөн улирлын улирч солигдох нь байгаль ертөнцийн тогтсон жам хууль, ямар ч хүний санаагаар шилжиж болдоггүй бодит ахуй билээ. Энэ тухай монголын содон яруу найрагч Д.Нацагдорж “Дөрвөн цаг” хэмээх шүлэгтээ:

Өвөл, хавар, зун, намар дөрвөн улирал

Уул, ус, нар, сартай нөхөрлөнө

Хүн бүр өтгөсийг үдээж нялхасыг угтан

Мянга мянган жил өчүүхэн ч чөлөө завгүй (1989:203) гэж ертөнцийн хүний “төрөх, өсөх, өтлөх, үхэх” нь ямар ч хүний санаагаар шилждэггүй зайлшгүй байгалийн жам хуулийг ахуйч үзлийн аргаар үнэн бодитой уянгалан шүлэглэсэн байдаг. “Жангар”-т хэдийгээр алтан бумбын орон “Өвөлгүй хаврын хэвээр, зунгүй намраар” хэзээд сайхан улиралтай байдаг. Энэ орны хүмүүс хэзээд өтөлж үхэхгүй үргэлжид хорин таван настай залуу зандан насны маягаараа байдаг гэж ахуйгаас хэтрүүлэн давуулж дүрсэлсэн боловч, урлагийн бүтээл болсоны хувиар, урлагийн үнэний гэрэл гялбаа гоо сайхны үнэ цэнээ алдаагүй, одоо ч гэсэн уншигч түмэндээ таалагдан сонирхогдсоор байна.

Жангарын баатруудын хүлэг морийг дүрслэхдээ:

Өмнө хоёр хөлөө

Өдрийн газар тавиад

Хойд хоёр хөлөө

Хоногийн газар тавиад (МТБЦ, 1988:165),

Салхинаас алд хурдан

Санаанаас дэлэм хурдан (МТБЦ, 1988:166) гэх буюу Жангарын эх нутгийн өргөн уудмыг зураглахдаа, таван сар гүйлгэснээр захад нь гарахгүй гэх мэтээр хэтрүүлэн давуулж дүрсэлсэн байдаг. Энэ дүрслэлүүд ч цаг, орон зайн маш өргөн ухагдахууныг хамарсан байна. “Өдрийн газар”, “Хоногийн газар” гэх энэхүү том орон зайг морины урд хоёр хөл, хойд хоёр хөлийн “нэг алхам”-аар товчилж “нэг л алхах” охорхон “цаг” ба нэг өдрийн газар хэмээх өргөн “орон зай” нь энэхүү хэтрүүлсэн давууллын ахуйгаас давсан цаг, орон зайн хоёр туйлыг харуулж чадсан байна. Иймэрхүү өдрийн газрыг нэг л алхаж явдаг хувилгаан хүлгээр “таван сар давхиад” ч Жангарын нутгийг туулж барахгүй аж. Энэ нь Жангарын нутгийг хэтэрхий өргөн уудам гэдгийг харуулах ч мөн “цаг”-ийн урт алслалыг илэрхийлнэ. Ийнхүү урт удаан цагт явж барамгүй өргөн их “орон зай”-н тухай дүрслэл нь Жангарын баатрууд ба хүлэг морьдын тэсвэр хатуужил, эр хүч, эрэлхэг хатан зоригийг илтгэхийн хамт Жангарын эх нутгийн хязгааргүй өргөн уудмыг харуулсан байна. Үүний зэрэгцээ тухайн үеийн монголчуудын зам харилцаатай холбоотой багажийн тухай ахуйгаас давсан хүслийг тусгаж, нэг алхмаар нэг өдрийн замыг явах хурдан хүлэгтэй болж, өргөн их талыг нисэн туулах хүслийг илтгэсэн байна.

“Жангар” туульд морины хувилгаан хурдац, бумбын орны өргөн уудам ба адуу малын өнөр олон байгааг:

Эгц гурван сарын газарт

Шөнийг шөнө гэлгүй

Өдрийг өдөр гэлгүй

Морины дэндүү хурданд

Эмээлийн хойд талд суугаад

Дээр гарсан тоосыг

Огторгуйд хүртэл суунаглаад явдаг болно.

Дахин гурван сар гүйлгэсэн цагт

Өл манхан цагаан уулын орой онцроод ирэв (Жангар, 1958:27),

Тэр үгийг сонсоод

Адууны захаас хоёр долоо хоног гүйлгээд

Арайхан гэж давж гарав...

Гурван хоногт гүйлгээд

Үхрийн захаас арай гарав...

Цаашиа гурван долоо хоногт гүйлгээд

Хонины захаас гараад ...” (Жангар, 1958:140-141) гэх мэтээр хэт давуулан хэтрүүлж дүрслэн, морины хурдацаар газар нутгийн өргөн уудам хийгээд мал сүргийн өнөр олныг үзүүлж, газар нутгийн өргөн уудмаар морины эр чадлыг товойлгон харуулжээ. Хувилгаан морины хурдан гүйдлээр хоёр долоон хоног гүйлгээд адууны захаас гарч, цааш гурван долоо хоног гүйлгэж үхрийн захаас гараад, бас гурван долоо хоног гүйлгээд хонины захаас гарч байна. Энэхүү ахуйгаас хэтийдсэн хэт хэтрүүлэл нь бумбын орны эд малаар элбэг баян, өнөр өтгөн байгааг зураглахын хамт тэр цагийн хүмүүсийн тал дүүрэн бэлчсэн тоолшгүй олон малтай болж, өнөр өтгөн амьдраасай гэсэн гэнэн нялхсаг хүсэл мөрөөдлийг тусгасан байгаа юм.

Хоёр. Уран нарийн зүйрлэлийн монголжуу онцлог

“Жангар” туульд хэрэглэсэн харьцангуй тохиромжтой зүйрлэл нь ч хэтрүүлсэн давууллын чанартай бөгөөд тод товгор үндэстний онцлог шинжтэй байдаг. Жишээлбэл: Жангарын хүлэг Аранзал зээрдийн цээжин биеийг “арслан”-тай, нуруу шийрийг “барс”-тай, хүзүү сээрийг “хун шувуу”-тай дэлийг нь “усны лянхуа”-тай тус тус зүйрлэсэн байдаг. Эдгээр амьд дүрслэг зүйрлэл нь баатрын хүлэг морины догшин, сүрлэг, эрэлхэг шулуун зан чанар ба үзэмжит чийрэг дүр байдлыг илтгэхийн хамт, нэн чухал нь нүүдэлчин үндэстэний өвөрмөц гоо сайхны сонирхолын онцлог ба уран сэтгэмжийн онцлогийг илэрхийлсэн байна. “Жангар” туулийн зохиогчид хөдөө талын өвс ургамал, араатан амьтанд даанч танил дасал болохоор өөрийн хүслийн хүлэг морины зан чанар, дүр төрхийг энд зүйрлэгдэхүүн болж байгаа арслан, барс, хун шувуу, усан лянхуа мэт амьтан ургамлын зан чанар, хэлбэр дүрсийн онцлог жич тэдний хоорондох ижил төсөөтэй талыг урнаар холбон сэтгэж, урлагийн өндөр үнэ цэнд хүргэж чадсан байна. Хэрэв хүлэг морины хур дэл ба усан дахь лянхуа цэцгийн дүрсийг сайн ойлгохгүй бол энэхүү хоёр зүйлийн бодис юмын адил бус мөртөө бас төсөөтэй байгаа ямар нэгэн ижил талыг хийсвэрлэн хураангуйлж хэрхэн чадах билээ? Ялангуяа энэхүү хоёр зүйлийн бодис аль нь алиныхаа зүйрлэгдэхүүн болж чадахыг нэн санаж олохгүй юм.

Жангар Хонгорыг магтахдаа:

Даарах цагт

Дах болдог Хонгор минь

Дэндэх цагт

Дун болдог Хонгор минь

Дийлдэх цагт

Хуяг болдог Хонгор минь

Давах цагт

Хүлэг болдог Хонгор минь (МТБЦ, 1988:366) гэж Хонгорыг дах, дун (бүрээ), хуяг дуулга ба хүлэг морьтой зүйрлэсэн байдаг. Тус зүйрлэл нь тал нутгийн уур амьсгалын нөхцөл, газарзүйн байц, дайн байлдааны онцлог жич эдгээрээс болсон хүмүүсийн хүсэл сэтгэл, хэрэгцээ шаардлага мэт үндэстний орон нутгийн онцлогийг харуулж цаашид Хонгорын ахуйгаас давсан хүслэнжсэн дүрийг шуун босгоход өвөрмөц гэрэл гялбааг нэмэрлэсэн байна.

“Жангар”-т иймэрхүү хэтрүүллийн шинжтэй үндэстний онцлог бүхий содон гайхалтай адилтгал зүйрлэлийг олонтаа хэрэглэсэн байна. Жишээлбэл: Жангарын Агай Шавдал хатны сайхан хөгжимдөхийг:

Ерэн нэгэн чавхдастай

Индэр мөнгөн хуураа аваад татвал

Хулсан дундаа өндөглөсөн хунгийн дуу гаргаад

Нууран дундаа өндөглөсөн нугасны дуу гаргаад

Арван хоёр аясаар чаши хуурдаад байдаг гэнэ (МТБЦ, 1988:7) гэж хуур хөгжмийн

яруухан аялгууг хунгийн дуу, нугасны дуутай зүйрлэн, сонсох сэрлийн дүрийг ч амилуулан зураглажээ. Гоо хатныг дүрслэхдээ:

Наашаа харвал наад далайн жараахай тоологдом

Цаашаа харвал цаад далайн жараахай тоологдом

Цуснаас улаан хацартай

Цаснаас цагаан царайтай (МТБЦ, 1988:6-7) гэх буюу

Гэгээнд нь үйл барим

Гэрэлд нь адуу манам

Гарах нарны суурийг дарам

Гантиг алтан шилийн цогтой

Тэгш дөчин цагаан шүдтэй

Тэргэр арван цагаан хуруутай

Мяндаа улаан уруултай

Тон тогосын толгойд нь

Тун наян хоёр үлгэр билгээ

Тодорхой төгсгөсөн

Галбир эгшигийн дуутай

Ганц Жангарын хатан (Жангар, 1958:207) гэх мэт уран нарийн зүйрлэн дүрсэлж гоо сайхны бүрдлийг шуун босгосон байна. Хатны царайн гэрэл гэгээнд цаад далайн загас жараахай ч үзэгдэж тоологдмоор энэхүү тунгалаг гэрлийн доор бүсгүй хүүхнүүд үйл бариад суумаар, адуучин эр адуун сүргээ манаад хономоор гэж зүйрлэн дүрсэлсэн нь ан агнаж, мал маллаж байсан монголчуудын ухамсар сэтгэхүйн үндэстэний онцлогийг товойлгон гаргажээ. Бас:

Хүүхэн хүрэн халзан нь өлөнгөөс боссон

Өл манхан туулай мэт гүйгээд

Хөлөөс нь үсэрсэн шавхаг нь

Сум мэт шуугиад байна

Гишгэн одсон газар нь

Хуучин худгийн ором болоод явна (МТБЦ, 1988:446) гэж зураглаад морины гүйдлийг өлөнгөөс боссон өл манхан “туулай”-тай зүйрлэж морин туурайнаас нь бутрах шаврыг “бууны сум”-тай зүйрлэж, морин туурайд онгилогдсон газрын ормыг хөдөө талын хуучин худагтай уран нарийн зүйрлэн дүрсэлж гарган сэрэл мэдрэхүйн дүрийг ингэж хүний сэтгэлд буутал уянгалаг, амьдлаг дүрсэлсэн байна. Иймэрхүү хэтрүүллийн шинжтэй үндэстний онцлог бүхий уран зүйрлэлүүд нь “Жангар” туулийн хэлний урлагийн ид шид хийгээд гоо чадавхын агуу гайхамшгийг тод харуулж байгаа юм.

Resume

"Jangar" epic is one of the most valuable works of art of the Mongolian people. The main reason came down from the century to centuries of "Jangar" epic is the features of literary language and role description. The distinctive feature of the "Jangar" epithet is its main reason for centuries.

In addition, it is a valuable work in the history of the Mongols as well as the many distinctive features of society, nomadic culture and economy. The literary language has played an important role in literary content and art description. It shows that the literary language of "Jangar" epic is more important than the main content. The importance of language is directly related to the communication of the verb. Therefore, it is required to conduct essential research on the literary language of "Jangar" epic based on the purpose of listening to "Jangar" epic.

Номзүй

Д.Нацагдоржийн зохиолууд. 1989. Үндэстний хэвлэлийн хороо.

Монгол тулгар бичгийн цуврал. Жангар-Нэгдүгээр боть. 1988. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо., 1988 он.

Монгол тулгар бичгийн цуврал. Жангар-Хоёрдугаар боть. 1989. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо.

Жангар (13 бүлэгт). 1958. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо.

Жангар (15 бүлэгт). 1982. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо.

Жангар: Жангарын туулийн судлал. 1993. Өвөр Монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо.

Гэрэл. 1994. Арван гуравт бүлэгт “Жангар”-ын гоо ухамсар” Өвөр Монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо.

Сарангэрэл. 1993. Тууль “Жангар” ба Монгол соёл. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо.